



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 6 сарын 29 өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Г Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Г
хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 407 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-ын 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,500,000,000.00 /нэг тэрбум таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.


2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2018 оны 6 сарын 29 өдрийн
252 дугаар тогтоолын хавсралт



“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эхний үлдэгдэл			Өөрчлөлт			Эцсийн үлдэгдэл		
		Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь	Хувьцааны т ширхэг	Нэмэгдсэн	Хорогдсон	Хувьцааны тоо ширхэг	Нийт үнэлгээ /нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 10,000 төгрөгөөр/	Дүрмийн санд эзлэх хувь
1	Б.Түвшин /ИВ75021210/	202,222	2,022,220,000.00	57,78%	103,333	1,033,332,857.00		305,555	3,055,552,857.00	61,11%
2	Ж.Бат-Орших /ЧС55031936/	54,444	544,440,000.00	15,56%	23,333	233,331,429.00		77,777	777,771,429.00	15,56%
3	С.Буянхишиг /УУ91070729/	38,889	388,890,000.00	11,11%				38,889	388,890,000.00	7,78%
4	Н.Энхболд /ХП85090113/	31,111	311,110,000.00	8,89%	13,333	133,332,857.00		44,444	444,442,857.00	8,89%
5	Г.Лхамсүрэн /ЧС79031732/	15,556	155,560,000.00	4,44%	6,667	66,668,571.00		22,223	222,228,571.00	4,44%
6	Л.Цэцэг- Эрдэнэ /ЧС52030464/	7,778	77,780,000.00	2,22%	3,333	33,334,286.00		11,111	111,114,286.00	2,22%
	Нийт	350,000	3,500,000,000.00	100%	150,000	1,500,000,000.00		500,000	5,000,000,000.00	100%